

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255020>

АНГЛИ ХЭЛ – СОЁЛТ ЭРДЭМТДИЙН МОРИН ХУУРЫН ТАЛААРХ
СУДАЛГААНЫ ТОВЧ ТОЙМ


Б.Батжаргал

Түлхүүр үг: Морин хуур, морин хуурын англи хэлээрх судлал

Англи – хэлт ертөнцөд өдгөө дэлхийн 88 орны хүн ам, газар нутаг тэдний хэл, соёл, сүсэг бишрэл, амьдрал ахуй ямар нэгэн байдлаар багтаж, тус хэлээр 1,5 тэрбум орчим хүн харилцаж байгаа нь орчлонгийн бусад хэлүүдтэй харьцуулахад хамгийн түгээмэл, унаган хэлтнүүдийнхээ тоогоор гуравдугаарт эрэмбэлэгдэж байна. Тус хэлээр хамгийн олон хүн харилцдаг орон болох АНУ – д цөөнгүй жил ажиллаж, амьдарсаны хувьд англи хэл нь шинжлэх ухаан, соёл урлаг, техник технологийн салбарын голлох хэл болохыг биеэр мэдэрч, Дэлхийн Хөгжмийн Форум (1st World Forum on Music (2005) in Los Angeles), Азийн судлал (Association for Asian Studies), Монгол судлал (Mongolia Society), Төв Евро – Азийн судлал (The Association of Central Euroasian Studies) зэрэг байгууллагаас зохиосон эрдэм судлалын хуралд удаа дараа илтгэл хэлэлцүүлж, энэ их гүрний Чикаго хотын Төв Номын сан (The Harold Washington Library Center) болон салбарууд, Конгрессын номын сангийн (The Library of Congress) монгол ном - судлалын фонд, Маршфельд хотын номын сан (The Everett Roehl Marshfield Public Library) болон Чикаго Их Сургууль (The University of Chicago), Калифорнийн Их Сургууль (The University of California), Блуумингтоны Их Сургуулийн (The Indiana University Bloomington) номын сан (The Lilly Library) зэрэгт хадгалагдаж буй монгол соёл урлагийг судалсан англи хэл – соёлт эрдэмтдийн бүтээлийг өөрийн хир чадлаар олж, мэдсэн баримт сэлтэд тулгуурлан, чухам тэд морин хуурыг хэрхэн судалсан талаарх товч тоймыг зураглан гаргах зорилгоор уг судалгааг хийлээ.

Англи хэл – соёлт эрдэмтдийн монгол хөгжмийг судалсан бүтээлүүдийг хоёр бүлэгт ангилан, авч үзэж болохоор байна. Энэ нь нэгдүгээрт, нэвтэрхий толь болон мэргэжлийн сэтгүүлд зориулсан судалгааны өгүүлүүд хоёрт, боловсролын ахисан түвшний нэгэн сэдэвт диссертац болон бие даасан номын бүтээл зэрэг болно.

Бүдүүвч № 1. Англи хэл – соёлт эрдэмтдийн монгол хөгжмийг судалсан бичвэрийн төрөл зүйлийн ангилал



Тус судалгаанд морин хуурыг судалсан англи хэл дээрх Америкийн Нэгдсэн Улс, Англи, Франц, Дани, Швед, Монголын эрдэмтдийн бүтээлд тандалт хийв.

Бүдүүвч № 2. Энэхүү өгүүлэлд хамрагдсан морин хуурыг англи хэл дээр судалсан улс орнуудын эрдэмтдийн оролцоо, хувь



Эхэнд англи хэл - соёлт эрдэмтдийн нэвтэрхий тольд зориулж бичсэн судалгааны өгүүллүүд морин хуурын талаар хэрхэн өгүүлсэнийг авч үзье.

1959 онд АНУ – ын Нью – Йоркийн “МакГрав- Хилл” хэвлэлийн газар 15 боть бүхий “Дэлхийн урлагийн нэвтэрхий толь” хэвлэн гаргасны X ботид нь “Монголын урлаг” (Hambis, 1959:244-250) гэсэн бичгийн 7 багана бүхий өгүүллийг Луис Хамбис¹ туурвижээ. Тэрбээр уг нэвтэрхий толийн өгүүллээ оршил (*Introduction*),

¹ Бүтэн нэр нь *Louis Georges Rémy Hambis* - Луис Жорж Реми Хамбис (1906 - 1978) нь Францын дорно дахины судлаач, Францын Хааны Коллежийн профессор, Төв ба Өндөрлөг Азийн судлалаар мэргэжсэн нэгэн байжээ. Тэрээр 1927 – 1928 онуудад Дээд Түвшний Судалгааны Өндөр Дадлага Олгох Сургуульд (ДТСӨДОС) Ф. Лонгрегээр гадаад орны түүх, И. Левигээр Дорно дахины эртний түүхийн хичээлүүд заалгажээ. Л. Хамбис

уран барилга (*Architecture*), уран баримал (*Sculpture*), уран зураг (*Painting*), алт, мөнгө болон бусад төмөрлөг урлал (*Gold-, silver-, and other metalwork*), гар урлал (*Minor art*), Монголчууд Өрнө ба Дорнын урлагийн холбогч болох тухай (*The Mongols as an artistic link East and West*) хэмээн ангилаад, ХХ зууны эхний хагаст англи, герман, франц, хятад, монгол, япон хэлээр гарсан өдгөө тун ховорд тооцогдох монголын тухай баялаг ном зүйд тулгуурлан, нягт нямбай бичвэр туурвижээ. Харамсалтай нь тус өгүүлэлд хөгжмийн урлаг тэр тусмаа морин хуурын тухай дурьдагдаагүй болно.

Хөгжмийн урлаг, түүх, онол, судлалын тусгайлсан нэвтэрхий толийг Окфордын Их Сургуулийн хэвлэлийн газар 1878 оноос эхлэн эрхлэн гаргаж ирсэн бөгөөд 1980 онд дахин засч, 20 ботиор шинэчлэн хэвлэсэн “Хөгжимчин ба Хөгжимчдийн Шинэ Гровын нэвтэрхий толь” – ийн 12 – р ботид Робертэ Хамайоны² “Монгол хөгжим” (Hamayon, 1980: 482-485) гэсэн өгүүлэл хэвлэгджээ. Тус өгүүлэл нь 1. Түүх (*History*), 2. Хөгжмийн үзэл санаа (*Musical concepts*), 3. Хөгжим, найргийн шинж (*Musical and textual characteristics*), 4. Уламжлалт хөгжим (*Traditional music*), 5. Хөгжмийн зэмсэг (*Instruments*), 6. Бөөгийн болон Бурханы шашны хөгжим (*Shamanic and Lamaist music*), 7. Шинэ хөгжим (*New music*) гэсэн бүтэцтэй ба “Хөгжмийн зэмсэг” гэсэн хэсэгт хуур - морин хуурын тухайд нэлээд гяргай, манайхнаас өөр нүдээр харан өгүүлжээ. Тэрбээр:

Хуур (khuur) гэх нэр томъёо чавхдаст болон ялтас бүхий еврей ятга (төмөр хуурыг хэлж буй Б.Б) хөгжмийн зэмсгийн аль алиныг нь төлөөлөх бөгөөд эдгээр нь хамгийн Монгол, унаган зэмсгийн ангилалд багтана. Энэхүү зэмсгүүд нь морины бэлгэдэл, зөвхөн эрэгтэй хүн хөгжимддөг, мэрэг төлгийн үүрэгтэй, их бага хэмжээгээр шид жатгын агуулга бүхий үгсийг даган хуурддаг зэргээрээ нийтлэг юм. Хамгийн ихээр түгэн тархсан нь морин хуур (morin khuur – морин – толгойт хийл; басхүү khil-khuur – хийл хуур гэдэг) болно. Босоо хийл (spike fiddle) нь модон хүрээ бүхий трапец хэлбэрийн бие, дуун хайрцаг болон ар нь ямааны арьс; модон чихний хайрцгийн дээд талд өндөр цамхаган амьтны чих бүхий морин толгойн (эсвэл лууны) сийлбэртэй. Хос чавхдасны нэг нь “бүдүүн” хийгээд аргил, нөгөө нь “нарийвтар” хийгээд өндөр дуутай ба нумын адил морины хялгасаар үйлдэнэ.

нь 1952 оноос ДТСӨДОС -ийн эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, 1965 – 1977 онуудад Францын Хааны Коллежийн Төв Азийн түүх, иргэншлийн тэнхимийн профессор, 1974 онд Төв ба Өндөрлөг Азийн Судалгааны Төвийн захирлаар томилогджээ. Тэрбээр 1955 онд Марко Пологийн “Орчлонгийн элдэв сонин” номын П. Пеллиот, Э. Муле нарын англи хувилбарт түшиглэн, франц хэл рүү тайлбар, газрын зураг сэлтийн хамт “Дэлхийг бүтээсэн нь: Гайхамшгийн ном” (*Le devisement du monde : le Livre des Merveilles*) нэрээр орчуулан гаргажээ.

² Францын хүн судлаач, угсаатны судлалч, хэл шинжээч, хатагтай Робертэ Хамайон (*Roberte Hamayon_1939-2025*) нь Сибирийн уугуул оршин суугчид болон Монголын уламжлалт бөөгийн шүтлэгийг голлон судалдаг ба 1967 – 1970 онуудад БНМАУ, Зөвлөлт Буриадын нутгаар аялсанахаа дараа нутагтаа буцаж очоод, өөрийн шавь нарын хамт 1968 онд Орчин Үеийн Дорно Дахины Хэлний Үндэсний Сургууль (INALCO) байгуулж, 2007 он хүртэл монгол хэл заажээ. Тэрээр Швейцарын Фрибургийн Их Сургуулийн Урлаг, Нийгмийн Шинжлэлийн тэнхимийн хүндэт доктор юм. Р. Хамайон нь “Монгол, Буриад дуунууд (*Chants Mongols et Bouriates; Vogue - LDM 30138*)” (1973) пянз, “Монгол хэлний дүрмийн үндэс” (1975), “Монгол хэлний гарын авлага” (1975), “Сүнсний эрэлд: Сибирийн бөөгийн тухай онолын бичвэрүүд ” (1988; 1990), “Бөөгийн шүтлэг: Шажны онол, практикийн өнөө ба маргаан” (2015), зэрэг бие даасан ном, судалгааны өгүүллүүд хэвлүүлжээ.

Арай бага дэлгэрсэн хийгээд хөгжимдөхөд илүүтэй дөхөм нь dörvön chikhtey khuur буюу khuuchir (босоо хийл) юм. Энэ нь Дорно дахинд ихэд тархсан бөгөөд ардаа чихтэй, ямааны өлөн бүхий хоёроос дөрвөн чавхдастай, хэлхээ нумтай (Хятадын hu-ch'in) зэмсэг; эх бие нь жижиг, цилиндр хийцтэй. Трапецан бие, хоёр чавхдаст шударан хөгжимдөх лют хуур болох tobshuur нь эдгээр хийлүүдийн Баруун Монгол жишиг нь юм. Amankhuur, аман khuur нь бөөгийн еврей ятга (энэ нь “jew’s harp” гэдэг “төмөр хуур” - ын англи хэлц болно Б.Б) болно... (Намаюн, 1980:484)

ХЭМЭЭЖЭЭ.

1996 онд 34 боть бүхий “Урлагийн нэвтэрхий толь” – ийг Оксфорд болон Нью – Йоркийн “Гров” хэвлэлий газар эрхлэн гаргасан ба түүний 21 – р ботид “Монгол” гэсэн толгой үгийн тайлбар бараг хорин нүүр (869-886) эзлэх бөгөөд 20 орчим эрдэмтэн – судлаачид хамтран, тус тусдаа оршил, худалдаа, шашин, уран барилга, ном, хуяг дуулга, хувцас, гоёл чимэглэл, арьсан эдлэл, төмөрлөг эдлэл, уран зураг, чулуун урлал – хадны сүг зураг, тамга, бичиг үсэг, уран баримал, модон урлал, түүх бичлэг, археологи, музей, үзмэрүүд гэхчилэн ангилан бичжээ. Энэхүү “Монгол” гэсэн толгой үгийн “8. Хөгжмийн зэмсгүүд” (Pegg, 1996:879-880) гэсэн дэд гарчгийг Англи эрдэмтэн, хатагтай К. Пээг³ туурвисан байна. Түүний тус нэвтэрхий толийн энэхүү өгүүллийн дийлэнх хэсэг нь морин хуурт зориулагдсан нь нэн завшаантай. К. Пээг морин хуурын тухай ийн өгүүлж байна:

Хөгжмийн зэмсгийг амьтны толгойгоор чимэглэх уламжлал эртнийх бөгөөд наанадаж 16 – р зуунтай холбогдоно. Үүнийг шанаган хуурын (Shanagan khuur – ladle fiddle) оройг луу болон далайн аймшигт амьтны толгойгоор чимэглэсэн байдал илтгэнэ. Баруун Монголын угсаатнууд өөр амьтны толгойгоор чимэглэх бөгөөд туульс хайлахад даган хөгжимддөг, хоёр чавхдаст, лют хуур болох tobshuur – ын оройд шувуун толгой байдаг...

Хоёр чавхдаст босоо хийл (морин хуурыг – Б.Б) хэмээн дуудахын учир нь бариул нь трапец хэлбэрийн арьс, модон дуун хайрцаг болон чавхдас тогтоогчийг туушид нь нэвтлэн гарч, заримдаа оройг нь морин толгойгоор чимэглэдэгт оршино. Энэ бол Халх Монголчуудын хуурын онцлог шинж болох бөгөөд тэд уг зэмсгээ морин толгойт - хийл (morin khuur) хэмээдэг ба Өвөр Монголын Цахар Монголчууд хийл хуур (khil khuur) гэж нэрлэдэг. Морин толгой нь монгол ардын язгуур урлаг, бөө мөргөлийн болон Бурханы шажны зан уламжлалд чухал ач холбогдолтой. Улаанбаатарын Дүрслэх урлагийн музейн үзмэрт морины гурамсан ногоон толгойтой зэмсэг байдаг (Цүлтэм, 1987, х. 110-11). Баруун зүгт орших Ойрад Монголчуудын хувьд нар ба сар, тогосын өд, Бурханы шашины хүслийг хангагч домогт эрдэнийн чулуу Чандмань зэрэг бэлэгдлүүдийг ашиглах ба заримдаа огт чимэглэхгүйгээр орхих явдал ч байдаг. Дөрвөн чавхдаст босоо хийл (dörvön chihtei khuur) нь дээр өгүүлсэнтэй төсөөт хувилбар бүхий бодит болон домогт амьтдын бэлгэдэл бүхий сийлбэртэй байдаг.

³ Кэролэ Пээг (Carole Pegg заримдаа Carolanne Pegg) нь Английн дуучин, хийлч, угсаатны хөгжим судлаач, эрдэмтэн. Кэмбрижийн Их Сургуулийн Нийгмийн хүн судлалын тэнхимд докторын зэрэг хамгаалсан ба өдгөө тус сургуулийн судлаач, тэнхмийн гишүүн. “Британийн Угсаатны хөгжим судлал” сэтгүүлийг үндэслэгч, “Британийн Эдийн засаг, Нийгмийн судлалын Зөвлөл” – ийг үүсгэн байгуулагч, “Хөгжимчин ба Хөгжимчдийн Шинэ Гровын нэвтэрхий толь” – ийн угсаатны хөгжим судлал хариуцсан редактор, Олон Улсын Уламжлалт Хөгжмийн Зөвлөлийн Британийн салбарын тэргүүн аж. 2001 онд монгол хөгжмийн тухай англи хэл дээрх анхны номыг (“Монгол хөгжим, бүжиг ба аман уламжлал”) туурвин, хэвлүүлсэн ба тус номын агуулга нь сүүлийн 30 жилд англи хэлээр гардаг нэвтэрхий толиудад монгол хөгжмийн тухай мэдлэгийн үндсэн лавлах болоод байна.

20 - р зууны туршид урласан иргэний хөгжмийн зэмсгүүд нь эртний Монгол болон Буддын шашны бэлгэдлээр чимэглэгдсэн хэвээр байв. Зүүн Монголд ардын аман зохиолд гардаг хагас матар /хагас зөгий, хоёр дахь толгойг морины толгойн доор, чавхдас цухуйх хэсгийн дээр, эсвэл ангайсан амнаас нь чавхдас гарган сийлдэг уламжлал буйг Копенгаген дахь Үндэсний музейн Цахар хийл хуураас (Хаслунд – Кристенсенсены цуглуулга, №18/39. R. 833) (Цүлтэм, 1987) харж болно. Хуурын ши ба арьс, модон дуун хайрцгийг ардын болон Буддын шашны муу зүгийн сүнс юмуу биет дайсан хийгээд дотоод сэтгэлийн эмх замбараагүйг төвшитгөхийн бэлгэдэл болсон алхан хээгээр (Лондоны Хорниманы музей – номын сан болон Парисын Хоммын музей, М.Н.67.101.7) чимэглэх нь элбэг байдаг. Заримдаа дуун хайрцгийн төвд хүч чадал, бүх зүйлийн хязгааргүй мөн чанарын бэлгэдэл болсон өлзий утсыг байршуулах нь бий. Морин хуурын ишийг чимэглэсэн хээ угалзны загвар нь эв нэгдэл, итгэлцэл, мөнхийн нөхөрлөлийг илэрхийлэгч хаан бугуйвч (Р. Пүрэвийг үзнэ үү), дугуй хээ, ургамлын дүрслэл болон Буддын шашны бэлгэдэл (Кембрижийн Их Сургуулийн Археологи & Антропологи музей, Линдгрений цуглуулга) зэргийг багтаасан байдаг. Далайн давалгаа, гал, үүл зэрэг байгалийн үзэгдэл болон ховор тохиолдолд мод, амьтдын дүрс зэргийг дууны царан дээр зурдаг (Парисын Хоммын музей, М.Н.57.61.3). Сүүлийн үед 17-р зууны Монголын Буддын шашны тэргүүн, уран барималч Занабазар (1635-1723) - ын зохиосон шинэ бичгийн эхний үсэг буюу 1924 оноос хойш тусгаар тогтносон Монгол үндэстний бэлгэ тэмдэг болсон соёмбоор хуурыг чимэглэх болсон...” (Pegg, 1996:879-880) хэмээн бичжээ.

К. Пээг “Хөгжимчин ба Хөгжимчдийн Шинэ Гровын нэвтэрхий толь” – ийн 2001 онд гарсан хоёр дахь хэвлэлийн 16 – р ботид хэвлэгдсэн “Монгол. Монгол хөгжим” (Pegg, 2001:922-933) гэсэн 12 нүүр - хуудас бүхий мэдээллийн нүсэр өгүүллийг бас туурвижээ. К. Пээгийн тус өгүүлэл нь Монгол Улсын тухай товч мэдээлэл, монгол хөгжим, оршил, уламжлалт хөгжим ба бүжиг (дуулаачийн хөгжим, уртын дуу, богино дуу, баатарлаг туульс, үлгэр, домог, магтаал, шившлэг үг, бэлэг дэмбэрэлийн үг, ерөөл, хараал), Наадмын хөгжмийн хэлбэрүүд (гийнгоо, цол, уухай), шашны хөгжим (ардын сүсэг, бөө мөргөл, буддизм, дууны үг, хөгжмийн зэмсэг, цам, шашны сэдэвт иргэний төрлүүд, хөөмий, хаалах, дуудлага, тамлага, бөөлөх, ян-иг, гүр дуу, Халх цам, эрлэгийн цам, “Саран хөхөөний намтар”), 20 – р зууны улс төрийн нөлөө (дуурь, бүжгэн жүжиг, цөөхүүл ба найрал хөгжим), хөгжмийн зэмсэг, бүжиг (бий, биелгээ, дуут бий, элкэндэг, үндэсний бий, мөргөлийн бий, цацал бий, ёохор, тарвага хөөрүүлэх), сүүл үеийн хөгжмийн трэнд гэхчилэн бүлэг хэсгүүдэд хуваагдан, дээр дурьдсан төрөл зүйлсүүдийг дэлгэр тайлбарлажээ.

Энэхүү өгүүлэлд морин хуур болон хуур, дөрвөн чихтэй хуур, икэлийн тухай аль нэгэн хөгжмийн төрөл зүйлийг тайлбарлах үест дурьдагдаж байна. Жишээлбэл: дуулах, хөгжимдөх үйлд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоог авч үзэхдээ: “... эмэгтэйчүүд ерөнхийдөө тууль хайлах, хөөмийлөхөд оролцдоггүй. Мөн хамгийн эрхэм уртын дууг эхэлж эрэгтэй хүн дуулдаг... Эмэгтэй хүн хуур, лимбэ, цуур, товшуур, ятга хөгжим тоглохыг хориглодог...” (Pegg, 2001:924) гэжээ. Тэрээр уртын дууны тухай өгүүлэхдээ: “...Халх ястны бүлгийн дунд гоцлол дуучин уртын дууг дуулж эхлэхэд, морин – толгойт хийл (morin huur) ба заримдаа хурууны зургаан нүхтэй, хажуу талаас нь үлээдэг хөндлөн бишгүүрээр (limbe) дуулаачийн хөг дууны аялгууны шугам, чимэглэлийг дагадаг...” (Pegg, 2001:925) гэжээ. Мөн энэ хуудсанд уртын дуучин Додьсүрэн, морин хуурч Арилдий нарыг 1989 онд Дундговь дахь гэрт нь авсан фото зургийг “Боржигон Халх” хэмээн тодотгон, оруулжээ. Мөн Баруун Монголын туульсийн тухай хэсэгтээ “...Баруун Монголын

баатарлаг туульсийг хоёр чавхдаст, товших лют хуур болох *topshuur* – аар, хааяа Захчингуудын дунд хоёр чавхдаст босоо хийл болох *ikil* – ээр дагаж хуурддаг...” (Pegg, 2001:926) хэмээжээ.

К. Пээг тус өгүүлэлийнхээ домгийн тухай өгүүлэх хэсэгтээ: “...домгийн хөгжим нь янз бүрийн хувилбарт хэлбэртэй байдаг. Морин хуурын үүслийн тухай “Хөхөө Намжил”-ын домгийг *morin huur* - аар дуулж, дагадаг; Баруун Монголчууд өөрийн түүхтэй холбоо бүхий аялгууг “*ikil*” – ээрээ эгшиглүүлдэг; Хөгжмийн зэмсгийн аялгуу нь амьтны домогтой үргэлжид холбогддог...” (2001:927) хэмээн тус тус өгүүлсэн байх аж.

“Американа нэвтэрхий толь” (*Encyclopedia Americana*) нь Хойд Америкт америк - англи хэлээр гарсан анхдагч (1829 оноос), англи хэлээр хэвлэгддэг гуравдагч том ерөнхий нэвтэрхий толь болох бөгөөд 2002 онд 30 ботиор гарсан ба 19 – р ботид нь Монголын тухай лавлах өгүүллийг (356 - 66) Норт Каролинийн Их Сургуулийн доктор асан, нэрт монголч Роберт А. Рупен (*Robert A. Rupen_1922 - 2015*) гуай бичсэн хэдүй ч “Соёл” гэсэн дэд гарчигтаа Монголд Урлагийн сургууль, Улсын Хөгжим ба Жүжгийн театр байгуулагдсан тухай л өгүүлсэнээс өөр хөгжмийн тухай зүйл дурьдаагүй байна.

2002 онд “Дэлхийн хөгжмийн Гарланд нэвтэрхий толь” (*The Garland Encyclopedia of World Music*) – ийн VII боть хэвлэгдэн гарсан нь бүхэлдээ Зүүн Ази (*Хятад, Япон, Солонгос*), Дотоод Азийн (*Монгол, Тува, Сибирь*) хөгжимд зориулагджээ. Тус нэвтэрхий толь нь АНУ – д анх 1988 оноос цувралаар гарч эхэлсэн бөгөөд анхны боть нь Африкийн хөгжимд зориулагдаж байсан бол өдгөө бүх тивийг хамарсан нийт 10 боть гараад байна. Энэхүү 7 – р ботийн VI бүлэгт “*Монгол хөгжим*” (Pegg, 2002: 1003-1023) гэсэн дэд гарчиг байх ба түүнийг Англи профессор К. Пээг туурвижээ.

К. Пээг монгол хөгжмийн тухай нэвтэрхий толийн өгүүллээ түүх, давтагдашгүй чанар, дуу авианы байгаллиг шинж, уламжлалт хөгжим, шашны хөгжим, орчин үеийн глобал болон орон нутгийн хөгжим хэмээн аймаглан авч үзжээ. Монголчууд Манж Чингийн үед Ар, Өвөр хэмээн хуваагдсаныг дурьдаад, мөнхүү Сибирь, Волга мөрөн хүртэл монгол олон ястан тархан суурьшдаг тухай өгүүлнэ. Тэрээр:

Халх, Буриад болон Өвөр Монголын зүүн хэсгийн бүлэг монголчууд уртын дууг хоёр чавхдаст, босоо хайрцаг бүхий “морин толгой” – т хийл болох морин хуураар (morin huur) дагаж хөгжимддөг. Үүнтэй төстэй хоёр чавхдаст, босоо бортогон хоолой бүхий хийл болох хуучир (huuchir) нь Төв Монголын Говийн нутаг, Зүүн Монголын тал нутаг болон Буриад дахь Буриадуудын дунд өргөн тархсан байдаг. Мөн эдгээртэй төрөл зэмсэг болох дөрвөн чавхдас бүхий дөрвөн чихтэй хуурыг хуурдана... (Pegg, 2002:1004) хэмээн бичжээ.

“Гарвардын хөгжмийн нэвтэрхий толь” – ийн “Зүүн Ази” (Wong, 2003:259-79) гэсэн толгой - өгүүллийн “Монгол” гэсэн дэд гарчигт монгол хөгжмийн тухай хоёр нүүр орчим лавлах багтжээ. Энэхүү нэвтэрхий толийн өгүүллийг Иллинойс Их Сургуулийн эрдэмтэн Исабел Вонг (*Isabel K.F. Wong*) бүхэлд нь бичсэн байна. И. Вонг “IV. Монгол” гэсэн бүлгээ 1. Түүх, 2. Хөгжим ба шашин (бөө мөргөл, буддизм), 3. Иргэний хөгжим (тууль дуу, гоцлол дуу), 4. Зэмсгүүд гэсэн хэсгүүд болгон ангилжээ. Монгол хөгжмийн зэмсгүүдийн тухай өгүүлэх сүүлийн хэсэгтээ тэрээр морин хуурын тухай ийн бичжээ:

Khuur (хуур) гэдэг нь монголын уугуул, нумт лот (хуур) - ын нийтлэг нэр болох бөгөөд эдгээрээс хамгийн алдартай нь морин хуур (morin khuur эсвэл khil khuur) юм. Энэ нь хоёр чавхдаст, трапец хэлбэрийн дуун хайрцаг, урт ши бүхий босоо нумт лот юм. Ишний төгсгөлд морь юмуу луун толгой сийлсэн байдаг. Босоо, нумт лот хуурын өөр нэгэн төрөлд дөрөв юмуу хоёр чавхдастай хуучир (khunchir) багтах бөгөөд энэ нь жижиг цилиндр хэлбэртэй дуун хайрцагтай ба Зүүн Монголд элбэг тохиодог...” (Wong, 2003:276)

гэсэн байна.

АНУ – ын Пенсилванийн Их Сургуулийн профессор, энэ цагийн дэлхийд нэр нь цуурайтан буй монголч эрдэмтэн, Х.Этвүүд 2004 онд “Монгол ба Монголын эзэнт гүрний нэвтэрхий толь” хэвлүүлсэн билээ. Түүний энэхүү толь – бүтээлд морин хуур монголчуудын шүтээн зэмсэг болох тухай хийгээд Ү. Ядамсүрэн гуай эртний хуурчийн хөргийг бүтээсэн болон Д. Яровой, түүний шавь нар морин хуурыг Өрнийн дууриалаар концертын шинэ зэмсэг болгон бүтээсэн зэргийг өгүүлжээ (Atwood, 2004:220-221).

2007 онд хэвлэгдсэн “Британика – шинэ нэвтэрхий толь” (*The New Encyclopædia Britannica*) – ийн 24 - р ботийн 330 – р хуудаснаас эхлэх “Монгол Улс” гэсэн толгой үг бүхий лавлах бичвэрийн “Соёлын амьдрал” (*Cultural life*) гэх дэд гарчигт: “... Хуурчид (Khurchins) - нь аман тууль, дуулийг тээж ирсэн ардын яруу найрагч, дуучид юм. Тэдний нүүрний хөдөлгөөн хийгээд үйл хөдлөл нь “Сумьяа ноён” болон “Дүйнхэр Да лам” гэх хурц, гашуун элэглэлт аялгуут жүжгүүдийг (vaudevilles) алдаршуулсан юм...” (Bira, 2007:335) гэжээ.

Өмнө хэдэнтэй нэр гарсан К. Пээг 2001 онд “Монгол хөгжим, бүжиг ба аман зохиол”⁴ ном туурвив. Энэ ном бараг гарсан дариудаа монголын хөгжмийн тухай мэдлэгийг англи хэл - соёлт ертөнцөд төлөөлөх, нэвтэрхий толиудын лавлагааны чанартай гол бүтээл болсон гэж хэлж болно. Өнөөдөр хорь гаран жил өнгөрсөн ч энэ чанараа бараг алдаагүй шиг байна. Тус номыг монгол хөгжмийн тухай англи хэлээр гарсан анхны номын бүтээл гэж үзэх хандлагатай хэдүй ч үүнээс яг 30 жилийн өмнө Нью – Йоркод, бүүр 1943 онд Стокольм хотноо хэвлэгдсэн “Монголчуудын хөгжим: *Дорнод Монгол*” (*The Music of the Mongols, Part I: Eastern Mongolia*) гэх номын бүтээлийг бас чиг дурьдвал зохилтой.

К. Пээгийн “Монгол хөгжим, бүжиг ба аман зохиол” ном нь:

1. Урлагийн тоглолт

I бүлэг. *Үндэстэн, Түүх, Газар нутгаа магтан дуулахуй*

2. Холбоос

3. Дуулаачийн урын сан

4. Зэмсэг ба бүжиг

II бүлэг. *Байгалийн сүнслэг дүрслэл*

5. Ардын сүсэг бишрэлийн зан үйл

6. Бөөлөхүй

7. Бурханы шашны гүйцэтгэхүйн урлагийн уламжлал

III бүлэг. *Нийгмийн харилцаа, Цаг хугацаа, Орон зайг бүтээхүй*

8. Нутгийн баяр ёслол

9. Спорт ба Тоглоом наадаан

10. Мал ахуй ба ан гөрөө

⁴ Pegg, Carole. (2001). *Mongolian Music, Dance, and Oral Narrative: Recovering Performance Traditions*. (Seattle: University of Washington Press.

IV. бүлэг. Улс төрийн төлөвшлийн өөрчлөлт

11. Социалист үндэстний онцлог
12. Зөрчил ба олон талт шинж
13. Төгсгөл үг гэсэн бүтэцтэй байх ажээ.

Уг номын хавтасны нүүрэнд ардын авьяастан морин хуурчийн фото зургийг, мөн 78, 79 – р хуудасны дундах фото зургийн хавсралтанд Баяд эмгэн Дүүдэй Увсын Улаангом дахь гэртээ икэлдэж буй мөн 2001 оны “Хөгжимчин ба Хөгжимчдийн Шинэ Гровын нэвтэрхий толь” – д хэвлэгдсэн Дундговийн Арилдий хуурчийн зургийг тус тус байршуулсан байх бөгөөд 71 – р хуудсанд морин хуурын бүтцийг график зургаар дүрсэлж, нэг бүрчлэн англи болон монгол үгийг латин үсгээр галигчлан, жагсаан бичжээ.

“Зэмсэг ба Бүжиг” гэсэн дэд бүлгийн “Нүүдэлчид: хийл, лют хуур, лимбэ” гэсэн гарчгийн дор “Босоо Хийлүүд” гэсэн хэсэгтээ *босоо хийл* (англиар *Spike Fiddle*) гэх төрөл ангилалд морин хуур болон хуурын төрлийн бүл зэмсгүүд болох шанаган хуур, морин хуур, дөрвөн чихтэй хуур, хуур, икэл, хуучир гэсэн зүйлчлэлүүдийг багтаан үзэж, зүйл тус бүрийнх нь ястан үндэстний гарвал, бүтэц хийц, хөгжимдөх байдлын онцлог, эдгээр зэмсгийн тухайд мэдээлэгчдийн нэрсийг дурьдан, тун чимхлүүр, өөр өнцөг, угсаатны хөгжим судлалын арга зүйн хандлагаар тайлбарлажээ. Морин хуураас гадна тус дэд бүлэгт ийм маягаар монгол үндэсний шанз, товшуур, лимбэ, цуур, аман хуур, ятга, ёочин хөгжмийн зэмсгүүдийг мөнхүү авч үзжээ (Pegg, 2001:67-95).

Хэннинг Хаслунд – Кристенсен⁵ “Монголчуудын хөгжим: *Дорнод Монгол*” (*The Music of the Mongolia: Eastern Mongolia*) ном наяд гаруй жилийн туршид англи – хэл соёлт ертөнцийн эрдмийн хүрээлэлд монгол хөгжмийн тухай сонгодог, тулхтай ойлголтын үндэс болсоор ирлээ. Тус ном анх 1943 онд Стокольмд хэвлэгдсэн ба

⁵ Хэннинг Хаслунд – Кристенсен (*Henning Haslund-Christensen_1896-1948*) нь Монгол орон, монголчуудтай хувь заяа холбогдсон, гэрийн хөгжмийн боловсролтой, гярхай нарийн мэдрэмжтэй, аялагч, угсаатны судлалч, нэгэн байжээ. Тэрбээр Дани үндэстэн бөгөөд улсынхаа нийслэл Копенгаген хотод урлагийн гэр бүлд мэндэлж, нутагтаа ерөнхий боловсролын гимнази болон цэргийн сургууль төгсөж, цэргийн алба хаасан бага тушаалын офицер цолтон аж. Х. Хаслунд – Кристенсен өөрийн анд, тамирчин Крэбстэй хамтран бичсэн “Булган тал” төсөл нь Данийн засгийн газрын тэтгэлэгт тэнцсэнээр тэд 1923 онд Монгол орныг зорьж, Хөвсгөл аймгийн Эрдэнэбүрэн, Цагаан – Үүр сумдуудад мал аж ахуй, газар тариалан, үслэг ангийн наймаа эрхэлж байгаад улс төрийн шахалтаар 1926 онд арга буюу үйл ажиллагаагаа зогсоожээ. Хэннинг Хаслунд монголд хайртай, дуу хөгжимд дуртай нэгэн тул төдөлгүй (1927 оноос) Шведийн физик газарзүйч, газрын зурагч, нэрт эрдэмтэн Свен Хэдинны (*Sven Hedin_1865-1952*) удирдсан Хятад – Швед – Шинжааны хээрийн шинжилгээний 300 жин тэмээ хөлөглөсөн, 6 орны 36 эрдэмтдийг багтаасан нүсэр экспедицид хөгжим судлаачаар ажиллан, эхлээд Хар Цахар Торгууд, Тайж нар, Цайдам, Өрөмч, Өргөө зэрэг нутгуудаар явж, Эдисоны фонограф дуу бичлэгийн машинаар олон тооны Монгол – Торгууд, Ижил мөрнөөс эгэн ирсэн Халимагууд, Халх, түмний дуу хөгжмийг судлан, бичлэг хийж, төдөлгүй 1938 онд Данийн Үндэсний Музей, дараа жил нь Данийн Вангийн Газар Зүйн Нийгэмлэгийн экспедицийг тус тус ахлан, Өвөр Монголд ахин ирж, Их Хянганы нуруу хавийн Манж, Сонгоол, Харчин, Баарин, Горлос, Буриад, Хайлаар, Цахар, Хорчин, Жалайр, Өөлд, Чивчин, Дагуур түмний дуу хуурыг судлан, дуу бичлэгийн аппаратанд шингээн, олон тооны монгол хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйлс цуглуулжээ. Тэрбээр 1948 онд Афганистанд насан өөд болсон байна.

1971 онд АНУ –д англи хэлээр дахин гарчээ. Энэхүү ном Х. Хаслундын нэрээр овоглон буй хэдүй ч хамтын бүтээл мэт сэтгэгдэнэ. Номын оршлыг Хятад – Швед – Шинжааны экспедицийг 1930 – аад онд удирдаж асан нэрт эрдэмтэн Свен Хэдин бичсэн бол “Монголын хөгжим болон зэмсгийн урьтал тайлбар” (х. 69-100) өгүүлэл болон Х. Хаслундын дуу бичлэгийн нэн шинэ аппаратанд (1930 – д оны үеийн) шингээсэн Манж, Сонгоол, Харчин, Баарин, Горлос, Буриад, Хайлаар, Цахар, Хорчин, Жалайр, Өөлд, Чивчин, Дагуур түмний 90 дууг нь Шведийн хөгжим судлаач, эрдэмтэн Эрнест Эмсхаймер⁶ ноот бичлэгт буулгасны дээр тус 90 дууны 12 – ынх нь дууны шүлгийг “Монгол яруу найргийн жишээ” (х. 39 - 68) нэртэйгээр К. Крөнбех англиар орчуулсан байна. Харин Х. Хаслундын өөрийнх нь бичсэн “Эртний Монголын ая хөгийн жимээр” гэсэн судалгааны өгүүлэл тус номын 13 – 38 –р хуудсанд залрах ажээ.

Х. Хаслунд Монголын эртний ая хөгийн жимээр аялангаа морин хуурын тухайд өгүүллийнхээ төгсгөлд аргагүй өгүүлж байна. Тэр морин хуурыг “хуур” (*khuur*), “морин – толгойт хийл” (*horse-head violin*) эсвэл “хийл хуур” (*khil-khuur*) хэмээн нэр оноосон байх аж. Тэрээр морин хуурын тухай ийн өгүүлнэ: “...Монгол настангууд Чингис хааны хүндтэй хөгч асан АРГУСУН ХУУРЧ буюу хуур хөгжимчин Аргусун болон Францын Гоо Филипп хаанд захидал илгээгч Персийн Монгол хаан АРГУН ХААН, түүний хуурч нарыг одоо хүртэл ярьж, өгүүлсээр байдаг...” (Haslund-Christensen, 1971:35) гээд цааш нь:

Цахар өвгөн, монгол анд маань “сүүлийн “морин - толгойт хийл” устахад, хуучны монгол хөгжим аниргүйднэ” гэж нэгэнтээ надад хэлсэн бөгөөд би түүнээс энэ итгэл үнэмллийг юунд үндэслэв хэмээн асуухад, тэрбээр надад анхны хийл хуур, монгол дууны үүслийн тухай нэгэн домог хүүрнэсэн билээ. (Haslund-Christensen, 1971:35) гээд бидний “Хөхөө

“Намжилын домог” гэж нэрлэдэг “Жонон хар морь” – ны домгийн хувилбарыг өгүүлсэн аж. Цахар өвгөний хэлж өгсөн, Х. Хаслундын англиар дамжуулсан энэхүү домогт Хөхөө Намжил гэдэг нэр огт дурьдагдахгүй. Хөгжим судлаач Э. Эмсхаймер тус номонд морин хуурын тухайд мөнхүү “хийл” гэсэн ерөнхий нэр томъёон доор хийц, хэмжээг нарийн илтгэн, өргөн судалгаатай өгүүлсэн байх ажээ (1971:82-89).

Английн Лийдсийн Их Сургуульд докторын зэрэг хамгаалсан угсаатны хөгжим судлаач Люси Рийс (*Lucy M. Rees*) 2021 онд “Монгол киноны хөгжим” ном хэвлүүлсэн ба “Монголын уламжлалт дуулаачийн болон дан хөгжим” (2021:15–19) гэсэн дэд бүлэгтээ морин хуурын тухайд:

Эл нутгийн хөгжмийн зэмсгийн төрөлд лют, хийл, модон үлээвэр хөгжим, аман хуурыг багтаадаг. Эдгээрээс хамгийн их түгсэн лют хуур бол 1921 оноос өмнө тууль болон бий биелгээ голлон дагаж хуурддаг байсан хоёр чавхдаст товшуур юм. Кино хөгжимд хамгийн их хэрэглэгддэг, чавхдаст, уламжлалт хөгжмийн зэмсгүүдээс хамгийн алдартай нь морин - толгойт хийл (morin khuur)

⁶ Эрнест Эмсхаймер (Emsheimer, Ernst _1904 – 1989) нь Германд мэндэлсэн Шведийн хөгжим судлаач аж. Тэрээр Венын болон Фрайбургийн Их Сургуулиудад төгөлдөр хуур, хөгжмийн онол, судлал үзээд, 1927 онд докторын зэрэг хамгаалжээ. 1932 – 1937 онуудад ЗХУ – н Ленинград хотын ШУА – ийн салбарт эрдэм шинжилгээний туслах ажилчнаар орж, Кавказ, Хятадад хийх шинжилгээний экспедицид хамрагдан оролцжээ. 1937 тэр Швед рүү цагаачилсан байна. 1962 онд тэрбээр Э. Стокманы хамт Өрнийн болон Өрнийн бус хөгжмийн зэмсэг судлах баг байгуулж, Studia Instrumentorum Musicae Popularis нэртэй нэг боть бүтээлийг 1969 онд хэвлүүлжээ.

юм. Энэхүү хоёр чавхдаст, нумт, босоо хийл нь шинийхээ оройд морин толгойн чимэгтэй (Улаанбаатарын “Эгшиглэн” хөгжмийн үйлдвэрт урласан морин хуурууд гэсэн фото зураг хавсаргажээ - Б.Б). Морин – толгойт хийл нь Монголын эртний болон өнөөгийн соёлд онцгой байр суурь эзэлдэг бөгөөд Улаанбаатарт байришилтай морин хуур урлаач Должинсүрэнгийн Уламбаяр үүнийг “Бүх нумт чавхдаст хөгжмийн эцэг” хэмээн тодорхойлж байна. Питер Маршийн судалгаа нь морин хуурт дагнан, тулгуурласан юм...” (Rees, 2021:16) гэхчилэн өгүүлжээ.

Өмнөх номонд нэр дурдагдаж буй Питер Марш⁷ нь “Морин хуур ба монгол дахь уламжлалын космополит үзлийн сэргэлт” (*The Horse-head Fiddle and the Cosmopolitan Reimagination of Tradition in Mongolia*) номын зохиогч, Калифорнийн Их Сургуулийн Зүүн Эрэг дэх салбарын профессор юм. Энэхүү ном 2009 онд хэвлэгдсэн ба одоогоор монгол морин хуурын талаар англи хэл дээр гарсан цор ганц бие даасан номын бүтээл болж байна. Тус номын үндсэн бүлэг хэсгүүдийн нэрийг дурьдвал, “Хувьсгалаас өмнөх монголын нийгэм дэхь хоёр чавхдаст хуурын уламжлал” (*Two-Stringed Fiddle Traditions in Pre-Revolutionary Mongolian Society*), “Хөгжмийн үндэсний соёлоо цогцлоосон нь” (*Building a National Music Culture*), “Зөвлөлт маягийн модернизм ба космополит үндсэрхэг үзэл” (*Soviet Modernism and Cosmopolitan Nationalism*), “Н. Жанцанноров ба монголын хөгжмийн үндсэрхэг үзлийн өнгөлөн далдлалт” (*N. Jantsannorow and the Reshaping of Mongolian Musical Nationalism*), “Ардын язгуур урлагийн сэргэн мандал ба морин хуурын сэргэлт” (*The Folk “Revival” and the Reimagination of the Horse-head Fiddle*), “Албан бус хөгжмийн түүхийн үргэлжлэл” (*The Persistence of Alternative Music Histories*) зэрэг болно.

Энэхүү ном П.Маршийн докторын сэдэв горилсон бүтээлийнх нь агуулга болох бөгөөд уг судалгааныхаа бүтээлийн гол сэдэв болгон морин хуур хөгжмийн зэмсгийг сонгосон ба энэхүү түлхүүрээр түлхүүрдэн, монголын эзэнт гүрний үеээс авахуулаад, тун саяханыг хүртэлх монгол түмний тахилга - шүтээн болсон энэхүү зэмсгийн үүсэл, түүх хийгээд хувьсал, хөгжлийн учир шалтгааны холбоосыг нь шинжээч - эрдэмтэн хүний нүдээр өөрийнхөөрөө тайлан онгойлгон, зураглажээ. Нэг талаар энэхүү бүтээл нь монголчуудын хөгжмийн товч түүх мэт болох ч уг

⁷ Питер К. Марш (*Peter K. Marsh*) нь Калифорнийн Их Сургуулийн Зүүн эрэг дэх салбар сургуулийн профессор, хөгжмийн түүхч юм. Тэрээр Индианагийн их сургуульд докторын зэрэг хамгаалж, Уэслийн Их сургуульд угсаатны хөгжим судлалын чиглэлээр магистр, бакалаврын зэрэг хүртсэн Монгол болон Азийн хөгжмөөр мэргэшсэн дэлхийд нэр түгсэн эрдэмтэн бөлгөө. Тэрээр Угсаатны Хөгжим Судлалын нийгэмлэг, Ази Судлалын нийгэмлэг, Олон улсын монгол судлалын холбоо, Монголын Нийгэмлэгийн жил бүр болдог хурал, Стэнфордын их сургууль, Зүүн Ази судлалын хүрээлэн (Беркли, Калифорн), Ази Номхон Далайн Олон Улсын Аюулгүй байдлын Төв (Калифорнийн Аюулгүй байдлын төв) зэрэг дэлхий даяар зохион байгуулагддаг хурал, симпозиумуудад судалгаагаа танилцуулсанаас гадна Германы Хөгжим судлалын нийгэмлэг (Веймар, Герман), Даяаршлын эрин үеийн Монголын соёлын нийгэмлэг (Беллингем, Вашингтон), Даяаршлын үеийн соёлын боловсролын олон улсын бага хурал (Улаанбаатар, Монгол), Төв Азийн туульсийн олон улсын симпозиум наадам (Улаанбаатар, Монгол) зэрэгт оролцсон.

2000 оны эхээр П. Марш Улаанбаатарт Америкийн Монгол судлалын нийгэмлэгийн анхны захирлаар цөөнгүй жил ажилласнаас гадна, 2000 – 2005 онуудад С. Гончигсумлаагийн нэрэмжит Хөгжим бүжгийн коллежийн гадаад эрдэмтэн - цагийн багшаар ажиллаж, монгол оюутнуудад барууны угсаатны хөгжим судлалын арга зүйн анхны чимээг дуулгасан гавьяатан. Тэрээр 2019 онд Хойд Америкийн Морин хуурын холбооны анхдугаар уралдаан – наадмын эрдэм шинжилгээний хурлыг Мичиганы Их Сургууль дээр зохион байгуулан даргалж, илтгэл хэлэлцүүлсэн. Тэрээр басхүү “Монголын поп, рок өөрийн дуу хоолойгоор” монгол хэлээр гарсан номын зохиогч билээ.

номыг хэвлэсэн хэвлэлийн газар нь (*Routledge*) “Монгол – Хөгжим - XX зуун – түүх ба шүүмжлэл” гэж тодотгсон байх. Энэ нь ч аргагүй юм. Зохиогч номынхоо дийлэнх хэсгийг 1921 оны Ардын хувьсгалаас хойшхи монголын хөгжмийн соёлд зориулж.

Зохиогч уг номондоо монгол судлалын тулгуур эртний сонгодог гар бичмэл, эх сурвалжуудыг шүүрдэн үзэх явцдаа “...монголын нууц товчоонд чавхдаст нумт хөгжмийн аль нэгэн зэмсгийн талаар дурьдсан болон хөгжимдөж байгаа талаар өгүүлсэн зүйл байхгүй...” (Marsh, 2009:17) хэмээжээ.

Энэхүү үзэл санаагаа бататгах үүднээс номынхоо тавдугаар бүлэгт Аргасун хуурчийн домгийг тусгайлан сэдэв болгон авч үзэхдээ:

Ц.Дамдинсүрэнгийн “Монголын уран зохиолын дээж бичиг зуун билэг оривой” (1959) номонд орсон Аргасун хуурчийн домог нь уйгаржин монгол бичгийн хуучин хэлнээс шинэ цагийн хэлбэрт оруулан үйлдсэн хөрвүүлэг...XVII зууны Лувсанданзангийн “Алтан товч” – ийн жинхэнэ эхэд түшиглээгүй...харин Германы эрдэмтэн И. Шмидтын 1829 онд хуулж бичсэн гар бичмэлд тулгуурласан тул монгол бичгийг гараар хуулан бичих явцад хуур (qiuur), хуурч болон хорч, хоор гэх зэрэг дуудлага ойролцоо үгийн ялгааг тэр бүр анзааралгүй хольж, хутган алдаа мадагтай бичсэн байж болох. (Marsh, 2009:128-129) гэжээ.

Морин хуурын үүсэл, нэрийн гарвалын тухай: Номын зохиогч П. Марш морин хуурын үүслийн тухай асуудлыг эхлэн хөндөхдөө Ардын Дуу Бүжгийн Чуулгын (өдгөө *ҮУИТ*) даргаар олон жил ажиллаж байсан Д. Батцэнгэл гуайн тэртээ 1978 онд Японы Токио хотод болсон Азийн хөгжмийн судлалын нэгэн хурал дээр тавьсан “Уртын дуу, хөөмий ба морин хуур” гэсэн англи хэлээр хэвлэгдсэн нэгэн илтгэлийг дурьджээ.

Энэ илтгэлд шанага гэх монгол гал тогооны нэгэн хэрэгслийн нэрээр нэрлэж байсан “шанаган хуур” - ын нэрийг латинаар галиглахдаа *shanagai xuur* хэмээн латин үсгээр андуу галигласныг анзаараад, цааш асуудлаа хөвүүлэн, угсаатны судлаач Д. Нансалмаа, хөгжим судлаач Ж. Энэбиш нарын морин хуурын үүслийн тухай бүтээлүүдэд өөрийн хариугаа барьжээ. Тэгээд шанаган хуураас морин хуур үүссэн гэх онолыг анх түүхч Г. Бадрах 1937 онд гаргаж тавьсаныг өгүүлээд, Ж. Бадраа гуайн цааш хөгжүүлэн олон төрөл, ангилалаар баяжуулсан хувь нэмрийг ч бас дурьдаж.

Номын зохиогч морин хуурын гарал үүслийн тухайд өөрийн дүгнэлтээ ийн өгүүлнэ:

Харамсалтай нь Бадрах ч тэр Бадраа ч мөн адил хуурын гарлыг айрагны утгуур - шанагнаас үүдэлтэй хэмээх онолыг түүхэн эх бүтээлүүддээ дурьдсан. Шанаган хэлбэртэй шанаган хуурыг эрт үед хэрэглэж байсан хэмээн өгүүлсэнийг нь үнэхээрийн шанагнаас үүдэлтэй гэдгийг нь нотлох боломжгүй. Тэдний айрагны утгуураас үүссэн гэх нотолгоог батлахад маш хүнд. Шанаган хэлбэртэй чавхдаст хөгжмийн зэмсэг нь мянган жил биш юм аа гэхэд олон зууны туршид Төв Азийн нийгэмд суурьшаар ирсэн нүүдэлчдэд дэлгэрмэл бөгөөд тэдгээр нь “хул” хэлбэртэй ба “лийр” хэлбэртэй гэсэн өөр зүйрлэл нэртэй байдаг ...” (Marsh, 2009:126) гэжээ.

Морин хуурын нэрийн гарвалыг хэл шинжлэлийн аргаар монгол судлагч нарын дундаас анхлан мөшгисөн, манай нэрт ардын урлаг судлаач Ж. Бадраа (1926 - 1993) гуайн “*Xiongnu khonghou*” – г монгол үг бөгөөд “кун гэдэг нь хун шувууны

хун, хэү гэдэг нь хуур, өөрөөр хэлбэл “хун толгойтой хуур” гэсэн үг юм ” гэсэн нотолгооны тухайд уг номын зохиогчийн саналыг толилуулбал: “...Хун хуур хэмээх үгийг монголынх хэмээсэн Бадраагийн санал нь цэвэр хийсвэрлэл юм. Хүннүгийн хун (kong) гэдэг үгийг кө-хө (kö-khö) язгуураас үүдэлтэй хуур (khugur) гэсэн монгол үгтэй хамаатуулсан Бадраагийн санаа нь монголын хэлшинжлэл болон үгийн гарвалзүйн онолын эндүүрэл юм ...” (Marsh, 2009:128) гээд Бадраагийн энэ саналыг нь тухайн үед түүхч Г. Сүхбаатар бүтээлдээ дурьдан, дэмжиж байсныг номынх нь нэр, хуудсыг заан тэмдэглэжээ.

Г.Жамъян ба Д.Яровой: хорьдугаар зууны монголын морин хуур хөгжмийн асуудлыг хөндсөн БНМАУ-ын Ардын жүжигчин, төрийн шагналт, хөгжмийн зохиолч, профессор Гомбодоржийн Жамъян (1919-ХI-28 – 2008-ИI-17) хуурчийг тойрч өнгөрвөл бөгөөд энэхүү номын зохиогч П. Марш бүтээлийнхээ бүхий л явц, анги бүлэг, дэд хэсэг бүрт энэ аугаа хүний нээлт, шинэчлэлийн эд эс бүрийг нягталж, саруулаар шүүн өгүүлж байна (Marsh, 2009:3, 55–57, 62, 66-67, 68, 70-71,101, 112, 114, 115, 116, 120, 137, 140, 141, 143, 148).

Петер Марш номынхоо оршилд: “...алдарт морин хуурч хөгжимчин, багш Г. Жамъян морин хуур заан, сургах сургалтанд хувьсгал хийж, тэрхүү сургалтын арга зүйдээ Европын морин хийлийн (violoncello) арга зүйгээс зээлдэн, өөрийн гайхам аргыг бүтээжээ...” (2009:3) хэмээн өгүүлнэ.

Уг номын “Хөгжмийн үндэсний соёлоо цогцлоосон нь” хоёрдугаар бүлгийн “Хөгжмийн боловсрол” гэсэн дэд сэдэвтээ эрдэмтэн – судлаач П. Марш, Г. Жамъян гуайн Хөгжим Бүжгийн Сургуульд багшлах явцдаа үндэслэсэн, морин хуурын сургалтын арга зүйн нарийн ширийнийг мэргэжлийн үүднээс тун цэгц, ончтой тодорхойлон хэлж байна.

Тэрбээр Жамъян гуайг морин хийл болон морин хуурын аль алиныг нь тэгш сайн эзэмшсэн хөгжимчин байсныг эхэнд өгүүлээд, ийм хандлага 1950 – д оны дунд болон сүүл үед монголын хөгжмийн амьдралд өрнөж эхэлсэнийг өчөөд, цааш арга зүйнх нь бүрдэл хэсгүүдийг:

Морин хуурын барил болон нумын барил, чавхдсан дээрх хурууны даралт – эрэмбэний ноот тэмдэглэгээ ба чавхдсан дээгүүр шүргэх нумын хөдөлгөөн зэргийг бүхэлд нь морин хийлтэй төсөөтэйгээр хөгжүүлэх замыг дагасан. Энэхүү өөрчлөлт нь Европ болон Европын сонгодог хөгжим хөгжимдөхөд морин хуурчдад тустай болсон. Тэр бас морин хуурд суралцах суурь дасгалуудыг хөгжүүлж, өөрийн хичээлдээ хэрэглэж байсан ба хожим нь түүнээ энэхүү зэмсэгт зориулсан стандарт сурах бичиг - ном болгон “Морин хуур сурах гарын авлага” (1978) нэртэйгээр хэвлүүлжээ...” (Marsh, 2009:55-56) гээд:

Түүний хуурдах болон хуурыг заан сургах арга зүйн сэдэл нь морин хуурын уламжлалыг шинэчлэхэд хүргэсэн юм. Хуураар хөгжимчдөд заавал суралцахаар зориулж урласан арпеджио болон гаммын эдгээр анхны хийсвэрлэлт цуврал дасгалуудаараа Жамъян уламжилж ирсэн харж, дууриан суралцах морин хуурын уламжлалт сургалтыг эвдсэн (Marsh, 2009:56) ...” гээд

Г. Жамъянгийн энэхүү арга зүй нь хөгжмийн бичиг ноотыг унших, улмаар хөгжмийн цагаан толгой болсон хөг, хэмнэл, өнгө болон бусад зүйлийг ойлгоход суралцагсдад итгэлтэй дөхөм болсон. Жамъян бас суралцагчиддаа хөгжмийн цэвэр өнгө, аялга гарган хөгжимдүүлэхийн тулд дүйцүүлэн хянах зорилгоор хичээлийн танхимдаа төгөлдөр хуур хөгжим

байлгадаг байсан... зэрэг энэ бүх хөгжимдөх болон заах арга зүй нь энэхүү ардын хөгжмийн зэмсгийн шинэ хөгжил болсон юм. (Marsh, 2009:56) гэжээ.

Морин хуурын хөгжимдөх арга барилын шинэ өөрчлөлтийг Г. Жамъян багш хийсэн бол уг шинэ хөгжмийн зэмсгийг нь гар урлалын бүтээлийн хувьд, дуу авиа болон акустик дизайны хувьд цоо шинээр үйлдсэн хүн бол Зөвлөлтийн хийл хөгжмийн урлаач Денис Владимирович Яровой (1921 - 1990) юм. Морин хуур урлаач Д. Яровойн тухай зохиогч П. Марш номынхоо хуудсуудад (2009:67-69,120,138) үнэн баримт түшин өгүүлэхийн сацуу түүний хамгийн авьяаслаг монгол шавь Д. Бууран болон дараагийн үеийн төлөөлөл болох Д. Уламбаяр нарын хуур урлаачдын бүтээлд үнэлэлт дүгнэлт өгч байна.

Монгол маягийн социализм халаагаа өгөх тун дөхөж байх 1988 онд бидний хэлж заншсанаар Англи буюу Их Британи Умард Ирландын Вант Улсын Кэмбрижийн Их Сургуулийн Хөгжмийн тэнхим “*XIII – XVIII зууны үеийн монголын хөгжмийн нэр томьёо*” (*Mongolian musical terminology from 13th to the 18 century*) гэсэн сэдэвтэй эрдмийн ажлыг соёрхон хамгаалуулжээ.

Энэхүү докторын диссертацийг туурвигч нь тухайн үест тун залуу хатагтай Андреа Никсон (*Andrea Nixon*) байх агаад, тэрбээр зэрэг горилсон бүтээлээ “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Улаанбаатар хотын Монголын Хөгжмийн Зохиолчдын Холбооны Жамцын Бадраад зориулав. Түүний туурвисан “Хөгжмийн нэр томьёо” (1956) ном бүтээл нь монгол ардын хөгжмийг үргэлжлүүлэн судлах миний онгодыг хөглөсөн бүлгээ” (Nixon, 1988:Нүүр хавтасны дотор тал) хэмээн эхний нүүрэндээ том үсгээр сийлэн бичсэн байх аж. Докторын зэрэг горилсон энэхүү судалгааны нэгэн сэдэвт бүтээл нь дундад эртний монгол хөгжмийн нэр томьёог бүхэлд нь англи хэлээр шүүн, авч үзсэн хүн төрөлхийтний анхны туурвил байх аа !

А.Никсоны “*XIII – XVIII зууны үеийн монголын хөгжмийн нэр томьёо*” хэмээх диссертаци нь 4 бүлэг (13 хэсэг), оршил ба дүгнэлт гэсэн үндсэн бүтэцтэй, англиар бичсэн 298 нүүр хуудас бүтээл аж.

Диссертацийн эхний бүлэг нь XIII зуунаас XVII зууны эхэн үе хүртэлх, удаах бүлэг нь XVII зууны эхээс XVIII зууны эхэн үе хүртэлх, гуравдугаар бүлэгтээ XVIII зууны эхнээс тус зууныг дуусталх монгол хөгжмийн нэр томьёоны асуудлыг авч үзсэн бол, эцсийн бүлэгт XVIII зууны эх бичгийн судалгааны дүнд илрүүлсэн монгол хөгжмийн нэр томьёоны жагсаалт, англи орчуулга - тайлал болон номзүй зэргээс бүрджээ.

Энэхүү нэгэн сэдэвт бүтээлийн эхний гурван бүлэгтээ зохиогч гурван төрөл зүйлийн эх сурвалжыг ашигласан байна. Эхэнд нь:

- янз бүрийн хувилбар эх бүхий монгол түүхийн монгол судрууд (“*Алтан товч*”, “*Сувд эрхи*” г.м), уран зохиолын бүтээл (“*Гэсэр*”, “*Жангар*”, “*Зүрхэн тольт*” зэрэг), хэлний толь (“*Нэрийн далай*”, “*Төвдийн хэл*”, “*Чухал хэрэглэгч*”, “*Олон сүм*”) элдэв захидлууд хийгээд худалдааны бичиг баримтууд зэрэг. Удаах нь:

- төвд болон санскрит эхээс голчлон хөрвүүлсэн монголжсон судар бүтээлүүд (“*Ганжуур*”, “*Данжуур*” их хөлгөн судраас өгсүүлээд, “*Бурхан багшийн арван хоёр зохионгуй*”, “*Субашид*”, “*Ногоон дарь эхийн тууж*”), эцэст нь:

- хятад (“*Юань Улсын судар*” тэргүүтэн), араб, перс (“*Судрын чуулган*”), зэрэг гадаад хэл дээрх зарим эх сурвалж хэлний толь (“*Манжийн хаанаас зохиосон гурав, дөрөв, таван хэлний толь*” тэргүүтэн) зэрэгт тусгагдсан монгол хөгжимтэй холбогдох нэр томьёог түүвэрлэх зэрэг гурван төрөл зүйл сурвалж болно. Чингэхдээ дээрх төрөл зүйл сурвалжуудыг монгол, орос, хятад, европ, америкийн

монгол судлагчид, Б. Владимирцов, П. Аалтоо тэргүүтэй сонгодог эрдэмтдийн тухай тухайн эх сурвалжийн орос, англи, франц, латин, герман зэрэг хэл дээрх судалгааны ололттой хамтатган нягталж, харьцуулсан байна.

Энэхүү судалгаанд америкийн домогт монголч эрдэмтэн О. Латтимор, английн профессор, алдарт монголч Чарльз Бавден, АНУ –ын Блуумингтоны Их Сургуулийн цуутай профессор агсан Хар Дорж, профессор К. Сагастер, Э. Эмсхаймер нарын зэрэг дэлхийн монгол судлалын ноён оргил эрдэмтэд саналаа тодорхой хэмжээгээр өгчээ.

А.Никсон тус докторын бүтээлийнхээ олон бүлэг хэсэгтээ хуурын тухай (Nixon, 1988: 23, 24, 26, 27, 32, 33, 37, 48, 60, 68, 103, 105, 107, 109, 130, 182, 193, 199, 208, 253, 264, 287, 296, 297) өгүүлж байна. Энэ бүгдийг тус бичвэрт бүрнээ багтаан өгүүлэх зорилго, боломжгүй тул тус докторын судалгааны эзэн Аргусун хуурчийн талаар өгүүлэх үзэл саналыг нь гагцхүү дамжуулахыг хичээе. А. Никсон энэ тухай:

Аргусун хуурч (Argusun Qurci) Чингисийн алтан хуурыг манах үүрэгтэй байсан ч нэгэн шөнө согтуурч, хоноод “түүнийг” авч явсан нь Чингисийн уур хилэнг бадрааж, хатуу шийтгэл оногдуулахыг завдтал, тэрбээр ухаалаг үгээрээ мултарч чадсан тухай нэгэн түүх өгүүлдэг. Энэ нь алтан лют байсан уу, қуғур байсан уу эсвэл тэрбээр лют хуурч байсан уу, эсвэл хорч (qor) байсан уу гэсэн маргаан байдаг. Инжиннаш “Хөх судар” түүхэн романдаа гуравдахь байр суурийг баримталж, Аргасун Хорголжин (Argusun Qorqoljin) Чингисийн охин Altan yorqu – тай шөнийг өнгөрүүлсэн тухай бичжээ (Nixon, 1988:284). Қуғур - т хэрэглэсэн бусад нэр үгс нь түүний мөн чанарыг тодруулж магадгүй юм. “Алтан Товч” – ийн өөр нэг шүлэгт Аргусунг Чингисийн алтан қуғур болон qotong қуғур – ыг харгалздаг байсан тухай дурдсан байдаг ч хожим Шастина “тюркский” (Туркийн) гэж орчуулсан бол Гомбоев орчуулалгүй орхисон байдаг. Потанин Гомбоевын хэвлэсэн хувилбарын янз бүрийн нэр томъёог авч үзээд, qotong - г (1899 х.321, цааш нь дэлгэрүүлсэн) “царица” Хатан хаан (qatun) гэсэн утгыг санал болгосон байна. Гаадамба (ТОИМ II х.163-166) Потанины саналд ямар нэгэн хариу бариагүй ч бас хөгжмийн зэмсэг биш гэж үзсэн ба харин Фоке Аргусунг “хүрээ дууч” - тай холбон өгүүлсэн. Өөр нэг хувилбар нь qutuγtu қуғур-тай холбогдох бөгөөд үүнийг Бавден “ариун” гэж орчуулсан байдаг. Хэрэв дуудлага нь қуғур, қуғурғи байсан бол хөгжмийн зэмсгийг хэлж байна гэдэгт эргэлзэх зүйлгүй. Гэсэн хэдий ч qur қurғи хувилбарууд нь хоёрдмол утгагүй хорч qor гэсэн утгатай мэт санагддаг. (Nixon, 1988:199-200) гэхчилэн Аргусун хуурч гэж хэлдэг бидний

тогтсон ойлголтыг янз бүрийн цаг үеийн, янз бүрийн унаган хэлт судлаачдын орчуулга, саналыг энэ мэт нухацтай харьцуулан эргэцүүлж, өөрийн саналыг дундуур нь шургалуулах ажээ.

2022 онд АНУ-д “Монголын эгшиглэнт ертөнц” (Mongolian Sound World) хэмээх ном хэвлэгдсэн ба Монгол улсын болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны монголчууд, МУ-ын Казак үндэстний хот болон хөдөөгийн амьдралд ХХ зуунаас хойш гарсан их өөрчлөлтийн дүнд үлдэж хоцорсон уламжлалт дуу хуур, хөгжимдөх урлаг, концертын болон поп рок ертөнц дэх шинэ эрэл хайгуул зэрэг хөгжмийн амьдралын олон талт үзэгдлийг тал бүрээс нь олон зохиогч, оролцогдын хамтын хүчээр тус ном бүтжээ. Тус номын редактороор уртын дуу судлаач, доктор, дэд профессор Сунмин Ён, Өвөр Монголын хөгжмийг голлон судалдаг доктор, дэд профессор Шарлотт Д’Эвелин, Жениффер С. Пост нар ажилласнаас гадна тус номыг бүтээлцэхэд хуур

урлаач Б. Баярсайхан, Ч. Отгонбаяр, хөөмий судлаач, доктор Эндрю Колвелл, Йоханни Куртет, Шарлотт Д'Эвелин, авьяаслаг хөөмийч, товшуурч, Эвэнк ястны төлөөлөл Тамир Харгана, профессор Питер К. Марш, К. Октябрь, Ребека Плуекхан, Женнифер С. Пост, Д. Цэрэндаваа, Сунмин Ён нар оролцжээ. Мэдээж энэ номонд морин хуурын тухай олон сайхан, гайхам судалгааны үр дүн тусгалаа олсон хэдүй ч тус номын дэлгэрэнгүй тайлбарыг дараачийн судлаач нарт үлдээе.

Англи- хэл соёлт эрдэмтдийн морин хуурын талаарх судалгааны товч тоймоо энд хүрээд өндөрлөж байна. Мэргэжлийн сэтгүүлүүдэд англиар хэвлэгдсэн морин хуурын тухай судалгааны өгүүллийн тоймыг бараг энд хөндөгдсөнгүй. Үүнийг бас түр хойш тавихаар шийдлээ.

Дүгнэлт

Англи – хэл соёлт эрдэмтэн, судлаачдын морин хуурын талаарх судалгааны тоймоос ажиглахад судалгааны арга зүй, өргөн далайцат хандлага, судалгааны туршлага, олон хэлний мэдэц зэрэг нь ихэд өндөрт байгаа нь илт байна. Тэднээс суралцах, үлгэрлэх, магад маргах, мэтгэх зүйлс ч байж болох талтай. Энэхүү судалгаанд дурдагдсан англи хэл дээрх морин хуурын талаарх өгүүлэл, судалгаа, ном, докторын зэрэг горилсон бүтээлүүдийн аль нь ч монгол хэлээр бүрэн эхээрээ орчуулагдаагүй, дийлэнх нь анх удаагаа монгол уншигчдын сонорт товч тойм хэлбэрээр хүрч байгаа болно. Морин хуурын тухай судалгааны англи хэл – соёлт эрдэмтдийн бүтээлээс ганц нэгийг нь ч болов бүрэн эхээр нь орчуулж, эх хэл дээрээ унших боломжийг өргөн олонд бүрдүүлэх аваас монгол түмний маань эрхэм дээд соёлын өв болсон молор эрдэнийн шүтээний тухай мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхэд бас нэгэн шинэ зам мөр нээгдэх буй за.

Ном зүй

Гадаад хэлээрх ном зүй:

- Atwood, Ch. (2004). *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*. New York: Facts on File.
- Bira, Sh. (2007). Cultural life. In *The New Encyclopaedia Britannica*. (pp.335-336). Chicago: Encyclopaedia Britannica.
- Emsheimer, Ernst. Preliminary Remarks on Mongolian Music and Instruments. *The Music of the Mongols: Eastern Mongolia*. (pp.69-100). New York: Da Capo Press.
- Hamayon, Roberte. (1980). "Mongol music." in *The New Grove Dictionary of Music and Musicians*. (pp.482-485). Edited by Stanley Sadie, first edition. Vol. 12. New York: Grove.
- Hambis, Louis. (1959). "Mongolian Art." in *Encyclopedia of World Art*. (pp.244-250). edited by Bernard S. Myers, Vol. X. New York: McGraw-Hill.
- Haslund-Christensen, H. (1971). On the Trail of Ancient Mongol Tunes. *The Music of the Mongols: Eastern Mongolia*. (pp.13-38). New York: Da Capo Press.
- Marsh, P. (2009). *The Horse-Head Fiddle and the Cosmopolitan Re-imagination of Tradition of Mongolia*. New York: Routledge.
- Nixon, A. (1988). Mongolian Musical Terminology From the 13th to the 18th Century [Doctoral Dissertation, Cambridge University].
- Pegg, Carole. (1996). "8. Musical instruments." in *The Dictionary of Art*. (pp.879-880). Edited by Jane Turner, Vol. 21. Oxford; New York: Grove.
- Pegg, Carole. (2001). "Mongolia, Mongol music." in *The New Grove Dictionary of Music and Musicians*. (pp.922-933). Edited by Stanley Sadie, second edition. Vol. 16. New York: Grove.
- Pegg, C. (2001). *Mongolian Music, Dance, and Oral Narrative: Recovering Performance Traditions*. Seattle: University of Washington Press.
- Pegg, Carole. (2002). "Mongol music." in *The Garland Dictionary of World Music*. (pp.1003-1023). Edited by Robert C. Provine, Yoshiko Tokumaru, and J. Lawrence Witzeleben Vol. 7. New York and London:

- Routledge.
- Rees, L. (2021). *Mongolian Film Music: Tradition, Revolution, and Propaganda*. London & Las Vegas: Routledge.
- Wong, Isabel. (2003). "East Asia." In *The Harvard Dictionary of Music*. (pp.259-279). Edited by Randel, Don Michael, fourth edition. Belknap Press.

Abstract

Official translations of music-academic research from English into Mongolian are quite scarce. However, today anyone, regardless of their level of education, who has access to the internet can easily get acquainted with any information in the world's languages in their native language with the help of AI or translation programs. At the moment, due to the imperfection of the translation program into Mongolian and the inaccuracy of term selection, it does not yet fully meet the needs of the academic community in the field of musicology. Acquiring and Access to highly specialized research, especially rare antiquarian books, is difficult to obtain in the conditions of Mongolian life due to the limitation of global payment through PayPal and the impossibility of direct delivery from the Amazon network.

The above-mentioned obstacles forced the author of this article to write this extensive panorama on the study of Morin Khuur in the English-speaking scholarly community. This article mainly touched on American and British scientists who devoted work to morin khuur. Today, the name of the British scholar, Professor of Ethnomusicology Carole Pegg, and the American professor, for the first time published a book in English about Morin Khuur, Peter Marsh, has become iconic in the field of World Mongol Studies. Of course, in this article I touched upon the work of the famous Swedish music researcher Ernest Emsheimer (1904 – 1989), the French Orientalist Roberte Hamayon (1939-2025), Isabel Wong, and other scholars who carefully studied the Mongolian musical tradition, including the heritage of the Morin Khuur.